

**ЧИН УЛСЫН ТӨРӨӨС МОНГОЛЫН ЯЗГУУРТАН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД
ОЛГОЖ БАЙСАН ЦОЛ, ӨРГӨМЖЛӨЛ: ЭРХЗҮЙН ОРЧИН БА
НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНД НӨЛӨӨЛСӨН НЬ**

Ч. УДААНЖАРГАЛ

Товч Агуулга: Аливаа улс орны түүхэнд гавьяа байгуулсан төрийн түшээд, цэргийн зүтгэлтнүүдэд цол, хэргэм шагнах нь тухайн төр улсын бодлогоо хэрэгжүүлэх хөдөлгүүр нь болсоор иржээ. Чин улсын үед төрд хир зэрэг үнэнч байх, аян дайнд оролцсон гавьяа зүтгэлийг нь үнэлэн сайшааж хааны хишиг болгон шан харамж олгох хир хэмжээ, цол хэргэмийн төрөл зүйл, олгох шат дамжлага болон цол хэргэмтнүүдийн эдлэх эрх мэдэл зэргийг хуульчилсан ажээ. Ингэснээр монгол ноёд язгууртнууд Чингийн төрөөс олгосон эрх мэдлийн хүрээнд Чингийн төрийг төлөөлөн орон нутгаа удирдах болжээ.

Нөгөө талаас цол, хэргэм шагнах нь монгол ноёдыг Чингийн төрд үнэнчээр зүтгүүлэх, Чингийн “тойрогт” татах нэг төрлийн арга байв. Энэ нь тухайн үеийн монгол язгууртан эмэгтэйчүүдийг ч тойрсонгүй. Энэхүү өгүүллээр Чин улсаас монгол язгууртан эмэгтэйчүүдэд олгож байсан өргөмжлөлүүдэд зориулан зохиосон эхүүд болон Чин улсын төрөөс монголчуудад зориулан хэрэгжүүлсэн хууль эрхзүйн баримтуудыг ашиглан Чин улсын төрөөс монгол язгууртан эмэгтэйчүүдэд олгож байсан өргөмжлөлийн эрхзүйн орчин болон нийгмийн ёс суртахуунд хэрхэн нөлөөлсөн талаар тодруулахыг зорив.

Түлхүүр үг: ёс суртахуун, Күнзийн сургаал, өргөмжлөл, Чин улс, эмэгтэйчүүд

Key words: Certificate of Honor, Confucius teachings, ethics, The Qing empire, women

1. Өмнөх судалгаа ба зорилго

čerig-ün küriyen-dür bağaturlan jïdkübei. urida yeke čerig ġarġaju jegün ġar-un arad-i quriyan abqui-dur. künesü mori-yi jalġamjilaġul-un kürgejü yerü saġaddaġsan ügei. qoyin-a tngri-yin tayilal ilegejüüleġsen olan qulaġayiči-yi nekejü bariqui-dur oljilaġsan olja-yi qoriġu sakiġad orgoġulju aldaġsan ügei. tursiġul-dur yabuġu ünen medege oluġad čerig-ün güng bütügebei. teriġülen

alalduju orugad. qulagayici-yi alaqi-dur biye-ben qayiralal ügei. güng bayigulju jidkügsen anu. yekede sayisiyaltai-yin tulada. qayiqamsigtu kesig-i dabqucaju kürtegebsüjokimui. edüge tusaqayilan čimayi olon-dur tusalagči güng ergümjileged uqağulqu ergümjilel ögbei ... či ilangğuy-a sidurğu ünen-i güyiçedkegtün. kürtügsen kesig-i büüötegeügtün. kiçiyenggüyile.¹

Язгууртнуудад сүр хүчийг бэлгэдсэн сүрлэг чамин цол гуншин², нийгмийн байр суурийг нь илэрхийлэх хэргэм шагнах тогтолцоо монголын төрт ёсонд уламжлагдсаар ирсэн талаар Ж.Гэрэлбадрах тэмдэглээд XIV-XVII зууны үед монголчуудын дунд хэрэглэгдэж байсан цол, хэргэм, зэрэг хэмээх нэр томъёоны утга учир, нийгмийн хэрэглээний талаас нь тайлбарласан.³ Тэрээр тухайн үед Монголын нийгэмд гарсан нэгэн өөрчлөлт болвоос бурханы шашин Монгол газар дэлгэрсэн. Үүнээс гадна бие даасан бага улсууд байгуулагдсанаар эзэн харьяатын ёс Их Монгол улсын үеэс хойш ахин сэргэсэнтэй холбоотой, “алтан ургийн хаад ноёд болон бие даан тусгаарлах болсон том язгууртнууд өөрсдийн сүр хүчийг өргөж, бусдаас онцгойрон ялгарахын тулд элдэв сүрлэг, басхүү гоёмсог чамин цол бие биеэсээ өрсөн зүүх” болж “ноёд язгууртнуудын цол хэргэм өөрчлөгдсөн, олширсон, ялгарал хүчтэй явагдсан” тухай өгүүлжээ.⁴

XIII-XIV зууны үеийн монголын язгууртан эмэгтэйчүүдийн цол, өргөмжлөлийн тухай судлаач Д. Идэр, С. Тайвансүрэн нар “Монголын Их Хатад” хэмээх бүтээлдээ, “Монголын язгууртан эмэгтэйчүүдийн угсаа гарал, эрх мэдэл,

¹ МУУТА М-25 Д № 1 ХН №12 А. Энэхүү бичвэрийг 1761 онд Тэнгэрийн тэтгэсэн хаанаас Халхын Түшээт хан Сундудворжид улсад туслагч гүн (*olon-dur tusalagči güng ergümjileged uqağulqu ergümjilel ögbei*) шагнахад дагуулан олгосон ухуулах өргөмжлөлийн хэсгээс ишлэн авав. Илтгэл шастирт өгүүлсэнээр, Сундудворж (*sundubdorji*) болвоос Цэвдэндоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучин есдүгээр он засаг хошууны бэйс залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай хэмээжээ. Цэрэндорж, Ц. нар (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гунгүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 69.

² Лэссинг, *čola ergükü, čola šangnaqi* гэдэг нь өндөр дээд алдар нэр хүртээх харин *kergem* бол дээд зэрэглэлийн албан тушаал, *kergem kürtekü* гэдэг нь тэрхүү албан тушаалын зэрэгт хүрэх. Lessing, F. *Mongolian-English Dictionary*, Bloomington: The Mongolia Society, Inc, 1995, 196, 458. *čola* (“*colo bumbi*”, “*colo tukiyembü*”) бол үе улирахгүй, Чингийн төрд гавьяа байгуулсан хүмүүсийг нийтэд алдаршуулах зорилгоор хүртээж буй нэршил (to grant a title or to enfeoff, to grant a title) харин *hergen* хэмээх нь зэрэг зиндаа (“rank” or “title”) юм. Norman, J. *A Comprehensive Manchu-English Dictionary*, Cambridge: Harvard University Asia Center Press, 2013, 58: 171.

³ Цол бол харьцангуй хийсвэр, хэргэм болвоос илүү тогтвортой, үе залгамжилдаг, өөрийн цолдоо тохирсон эрх ямба эдэлдэг хэмээжээ. *Kergem* гэдэг нь өргөн утгаараа албан тушаалыг илтгэх бөгөөд хааны сангаас цалин пүнлүү авдаг бөгөөд үе улиран сонгогддог. Тэрээр зэрэг хэмээх ойлголтыг аливаа цол, хэргэм албан тушаалыг дэсэлж эрэмбэлж байгаа хэлбэр хэмээн тайлбарласан байна. Гэрэлбадрах, Ж. “Дөчин, Дөрвөн хоёрын” Монгол улсын язгууртны цол зэрэг, Улаанбаатар: Бемби сан, 2010, 15-17.

⁴ Гэрэлбадрах, Ж. “Дөчин, Дөрвөн хоёрын” Монгол улсын язгууртны цол зэрэг, Улаанбаатар: Бемби сан, 2010, 13-18.

байр суурь нь тэдний цол, зэрэг дэв”-ээр тодорхойлогдох бөгөөд хамгийн эрхэм хүндтэй цол өргөмжлөл болвоос “үжин”, “хатан”, “бэхи”, “гүнж” зэрэг хэмээгээд⁵ Юань улсын үед монгол хатдад олгож байсан өргөмжлөлүүдийн⁶ гол утга санаа нь, “тухайн хатны үзэсгэлэн гоо, авьяас билиг, эрдэм ухаан, зан ааль, түүхэн гавьяа зүтгэлийг илэрхийлсэн” байдаг тухай дурдсан.⁷

Чин улс ба монголчуудын харилцааны талаарх судалгаандаа Элвэрског, “цол, хэргэм шагнах нь зөвхөн Чингийн төрийн шинээр бий болгосон зүйл биш тухай дурдсан байдаг.⁸ Харин Ж. Урангуа бүтээлдээ, Чин улсын гадаад харилцаанд, “хүд ургийн холбоо тогтоох, эд эрдэнэс, цол хэргэм шагнах” зэрэг бодлого голлох агаад тухайн үед монгол язгууртнуудад цол, хэргэм, зэрэг⁹ олгох нь Чин улсын хуульд албан ёсоор тусгагдсан талаар, “Манж Чин улс монгол язгууртан ноёдын улс төрийн байр суурь, Чин улсын төрд хир зэрэг үнэнч байх, аян дайнд оролцсон гавьяа зүтгэлийг нь харгалзан хэргэм зэрэг олгох болсон бөгөөд Чин улсын хууль дүрмээр хэргэм хүртсэн ноёдод хувцас засал болон эрх ямбыг тогтоон”¹⁰ өгөх болсон бөгөөд монгол язгууртнуудын цол хэргэмийн хэрэглээ, ач холбогдол нь суурин соёл иргэншил бүхий Европын орнуудын язгууртнуудын цол хэргэмээс дутахааргүй түвшинд хөгжиж ирсэн ч Чин улсын үед монгол төрийн энэхүү уламжлал нь харь улсын нөлөөнд өртсөн тухай дүгнэсэн байна.¹¹

Чин улсын үед ноёд язгууртнуудад хэргэм залгамжлах болон цол шагнахад дагалдах өргөмжлөлийн хэв загвар, хэмжээ, төрөл зүйлийн талаар эрдэмтэн Вольфганг Франке дэлгэрэнгүй судалгаа хийж, *kao-ming (gāoming-great fame,*

⁵ Идэр, О., Тайвансүрэн, С. *Монголын Их Хатад*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2019, 17-18.

⁶ “Монгол хэлний их тайлбар толь”-д “*ergümjilel*” гэсэн нэр үгийг цол хэргэм өргөмжлөхөд дагуулан олгодог батламж хэмээн тайлбарласан бол Лэссинг *ergymzile* гэвэл зэрэг нэмэх, зэрэг өргөмжлөх, (өндөр) хэргэм зэрэг шагнах хэмээгээд *ergymzilen olхуху* гэдэг нь цол хэргэм шагнах, *ergymzilel* хэмээвээс цол, хэргэм шагнасан батламж, түшмэдүүдийн төрсөн эх болон эхнэрт олгох цол хэмээн тайлбарласан. Lessing, F. *Mongolian-English Dictionary*, Bloomington: The Mongolia Society, Inc, 1995, 326. Я. Цэвэл, өргөмжлөх гэдэг нь хүндэтгэн өргөж тэмдэглэх; нэр цол өргөмжлөх; нэхэж өргөмжлөх (нас барсан хойно нь гавьяа зүтгэлийг нь илэрхийлж тэмдэглэх) хэмээн тайлбарласан байна. Цэвэл, Я. *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966, 443.

⁷ Идэр, О., Тайвансүрэн, С. *Монголын Их Хатад*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2019, 19.

⁸ Elverskog, J. *Our Great Qing*, Honolulu: University of Hawai'i Press, 2006, 68.

⁹ “Хэргэм гэдэг нь дээд зэргийн гавьяа цол болно. Үүнийг Манж Чин улсад дагаар орох юм уу манжийн төлөө байлдаанд явж гавьяа байгуулсан хүмүүст олгох ёстой. Хэргэм нь ван, бэйл, бэйс, гүн гэсэн дөрвөн янз байдаг” харин “зэрэг нь хэргэмд хүрэхгүй бага зэргийн гавьяа зүтгэлийг илэрхийлж, дансанд тэмдэглэдэг шагналын зүйл юм” хэмээжээ. Урангуа, Ж. *Хэргэм, зэрэг, цол өргөмжлөхүй*, Улаанбаатар: Наранбулаг Принтинг, 2000, 12-13.

¹⁰ Урангуа, Ж. *Хэргэм, зэрэг, цол өргөмжлөхүй*, Улаанбаатар: Наранбулаг Принтинг, 2000, 12.

¹¹ Урангуа, Ж. *Хэргэм, зэрэг, цол өргөмжлөхүй*, Улаанбаатар: Наранбулаг Принтинг, 2000, 109-110.

prestige мөн *gàomìng- imperial mandate, titled lady*¹²) өргөмжлөлийг доод зиндааны язгууртан ноёдод цол өргөх болон үе улиран хэргэм залгамжлахад харин *ch'ing ming* (*cè mìng- emperor's order to confer titles of nobility on his wives, princes*¹³) өргөмжлөлийг хятад, манжаас өөр үндэстэн, угсаа гарвалын ноёд язгууртнууд болон хэргэм улиран залгамжлахгүй тохиолдолд олгодог байсан тухай дурдаад *ts'ê* (*cè- book, booklet, volume*¹⁴) хэмээх алтадсан болон мөнгийг алтаар бүрсэн тэмдэг бичгийг дээд зиндааны ноёд язгууртнуудад олгодог байсан талаар өгүүлжээ.¹⁵

Харин судлаач Татьяна Панг ОХУ-ын Санкт-Петербургийн Шинжлэх ухааны академийн Дорно дахин судлалын институтэд хадгалагдан буй Чингийн төрөөс язгууртан ноёдод олгосон нийт 16 ширхэг өргөмжлөл хадгалагдан буйгаас хоёр өргөмжлөлийг онцлон судалгааны эргэлтэд оруулсны эхнийх нь Энх-Амгалангийн 55-р он (1716)-д хамрагдах Манж угсааны ноён Үрчэн (Urcen)¹⁶-д “*ilaci jergi gurun be dalire / janggin fungnefi g'aomimng*” өргөмжлөл олгосон тухай юм. Дараагийн судалгаа бол Тэнгэрийн тэтгэсний 49-р онд (1785) засаг хошууны бэйс Сундувдоржийн¹⁷ дараа авсан гэргийг “Бэйсийн хатан” өргөмжлөн олгосон өргөмжлөлийн тухай бөгөөд тэрээр уг өргөмжлөлийн Манж болон Монгол хэл дээрх эх бичвэрийг бүрэн эхээр галиглан эхэд зарим нэгэн тайлбарыг хийжээ.¹⁸

Хөх хотын Нийгмийн шинжлэх ухааны академийн номын санд хадгалагдан буй “*manju ulus-un üy-e üjümücin-ü wang nar-tu üy-e ularin jalgamjilaqu kiged qatud-tu öggügsen jerge-yin jarlig*” хэмээх бүтээлд Үзэмчин аймгийн засаг хошой чин ван Пунцагравдан (1748) болон Махасуха (1749) нарын хатдад 1748 болон 1749 онуудад тус тус олгосон “Хошой сэцэн чин вангийн хатан”-ы өргөмжлөлийн тухай судалгаандаа Вэйт Вироника язгууртнуудад үе улиран хэргэм залгамжлах болон байгуулсан гавьяаг магтан сайшаан цол өргөмжлөх нь Чин улсын үед улам

¹² De Francis, J. *Chinese-English Comprehensive Dictionary*, Honolulu: University of Hawai'i Press, 2003, 293.

¹³ De Francis, J. *Chinese-English Comprehensive Dictionary*, Honolulu: University of Hawai'i Press, 2003, 87.

¹⁴ De Francis, J. *Chinese-English Comprehensive Dictionary*, Honolulu: University of Hawai'i Press, 2003, 86.

¹⁵ Franke, W. “Patents for Hereditary Ranks and Honorary Titles during the Ch'ing Dynasty,” *MonumentaSerica*, vol II fasc. 1/2 (1942), 38-76.

¹⁶ Pang, T.A. “The Imperial patent of the Kangxi period in the Collection of the Institute of Oriental manuscripts, Russian Academy of Sciences,” International Conference. *China and Central Asia from the Pre-Mongol to the Post-Mongol periods: History and Culture*. Conference Proceedings. 2017, 64-66.

¹⁷ Тайлбар 2-ыг харна уу.

¹⁸ Pang, T.A. “A Manchu-Mongolian Diploma Given to the Wife of Mongolian Nobleman in Written Monuments of the Orient. Russian Academy of Sciences,” *Institute of Oriental Manuscripts*, 2015 (1), 78-86.

боловсронгуй болсон хэмээгээд тухай хоёр хатанд олгосон өргөмжлөлүүдийн эх бичвэр үндсэндээ бараг адилхан тухай дурджээ.¹⁹

Чин улсаас монгол ноёд язгууртнуудад олгож байсан үндсэн гурван төрлийн өргөмжлөлүүд нь “Монголын засаг захиргаа, ноёдын талаар явуулсан бодлого, ялангуяа язгуурнуудын намтар, үйл ажиллагаа, угсаа залгамжлал, засаг хошууны хувирал өөрчлөлтийг” судлахад чухал сурвалж болох тухай судлаач Э.Жигмэддорж өгүүлжээ.²⁰

Харин Чин улсаас монгол язгууртан эмэгтэйчүүдэд олгосон одоогоор бидэнд мэдэгдэж буй нэгэн өргөмжлөлийг 1636 онд Хунтайжаас Хорчины Жэрэ болон Бумбатай хатдад олгож байсан тухай судлаач Ван Пэйхуан дурдаад уг эхийг бүрэн эхээр нь хэвлүүлсэн ажээ.²¹

Чин улсын үед монгол язгууртан эмэгтэйчүүдэд олгож байсан цол, өргөмжлөлүүдийн нийгмийн үүрэг, үзэл санаа болон эрхзүйн орчны талаар нарийвчилсан судалгаа одоогоор хараахан үгүй. Энэхүү өгүүллээр, Чин улсын төрөөс монгол язгууртан эмэгтэйчүүдэд өргөмжлөл олгох хууль эрхзүйн орчин, өргөмжлөл олгох шат дараалалыг тодруулахын сацуу язгууртан эмэгтэйчүүдэд олгосон өргөмжлөлүүд дэх эх бичвэрүүдийн агуулгыг задлан шинжилсний үндсэн дээр Чин улсаас монгол эмэгтэйчүүдийн нийгмийн ёс суртахууны талаар ухуулан баримталж байсан үндсэн үзэл санааг тодруулахыг хичээв. Үүнд, Монгол улсын түүхийн төв архивд хадгалагдаж буй хатдын цол өргөмжлөлд зориулан зохиосон эхүүд болон Чин улсын төрөөс монголчуудад зориулан хэрэгжүүлсэн хууль эрхзүйн баримтууд болон бусад бүтээл, сурвалжуудыг ашиглав.

2. Чин улсын төрөөс Монголын язгууртан эмэгтэйчүүдэд өргөмжилсөн цол, өргөмжлөлийн эрхзүйн орчин

Чингийн төрд үнэнчээр зүтгэсэн монгол язгууртан ноёдод өндөр их шан харамжаас гадна хэтэрхий дөрөв хэмээх “*wang*” (*cing wang*, *jüng wang*), “*beyile*”, “*beyise*” болон “*güng*”-ийн хэргэмийг өргөмжилж, Чингийн эрхшээлд орохоос

¹⁹ Veit, V. “A set of 17th to 19th Century Manchu-Mongolian Patents for Hereditary Ranks and Honorary Titles,” *Tumen jalafunjecenaku: Manchu studies in honour of Giovanni Stary*, Weisbaden: Harrassowitz, 2006, 245-253.

²⁰ Жигмэддорж, Э. “Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй нэгэн өргөмжлөлийн тухай”, *Quaeriones Mongolorum Disputatae*. vol.5. Tokyo, 2009. Мөн Jigmeddorj, E. “The Certificate on the titles Inheritance written in Manchu and Mongolian text given to Dürbed Dalai khan by Qing dynasty,” *Oyirad Studies*. vol.3. Budapest, 2017, 9-27.

²¹ Wang, Peihuan., “Hong Taiji’s Patent to His zhuangfei Concubine Bumbutai”, *BeitragezurGeschichte, Sprache und Kultur der Manchuren und Sibe*. Martin Gimm, Giovanni Stary, Michael Weiers (Hrsg). Wiesbaden: Harrassowitz, 1998, 145-155 (AetasManjurica 6).

өмнө улс гэрээ бие даан удирдаж байсан монгол язгууртан ноёд, ялангуяа Чингисийн алтан ургийн ноёд Чингийн хаанаас өгсөн эрх мэдлийн хэмжээнд Чингийн төрийг төлөөлөн нутаг орноо удирдах эрхтэй болдог болов. Тэдгээр ноёд язгууртнуудын хувьд ийнхүү эрх мэдэл, цол, хэргэм өргөмжлөгдөн, эхэн үедээ “хагас тусгаар байдлаа хангаж буй мэт байсан” авч XVIII зууны үеэс Чин улс болон монголчуудын харилцаа өөрчлөгдөн²² эзэн-харьяатын харилцаан дээр үндэслэж, хаан төрд үнэнчээр зүтгэснийхээ хариуд “хүнд их хишиг” хүртэж, улмаар бүхий л улс үндсээрээ энх амгалангаар амьдарч буй тухай нийгмийн суртал ихэд дэлгэрснийг XVII-XVIII зуунд зохиогдсон монголын түүхэн зохиол бүтээлүүдээс бэлхэнээ харж болно. Жишээ нь Эрдэнийн товчид Дээд эрдэмт хааны тухай өгүүлэхдээ:

Eu-e-ber jasaγci qayan uu bars jiltei: Doloγan nasun-iyan: ga bičin jile Kitad-un Dayiming Qayan-u altan siregen deger-e saγuju: Eye-ber jasaγci qayan kemen бүкү жүг-dür aldarsiyad...yerüngkei ulus . ayimaγ-taki qad noyad: түsimed-nuyud-ta: vang beyile. beyise güng-üd kemekü terigüten čolas-i ögčü: tus бүri күндү könggen jergeber anu qayiralayad: күr yeke ulus-i tulγurča jasan: qas yeke törö- yi esen tayibung bolγabai.²³

хэмээн өгүүлсэн байдаг.

Энэхүү эзэн-харьяатын харилцаа нь хаан төрөөс хэргэм, цол шагнах, цалин пүнлүү олгон, хүртээж буй халамж ивээлийг төрд үнэнчээр зүтгэн хариулах гэсэн санаанд тулгуурлажээ. XVIII зууны үеийн монголын утга зохиолын хэлэнд гарсан өөрчлөлтийн тухай бүтээлдээ Этвүүд, “*kesig-tü mörgümüi*” эсвэл “*kesig kürtekü*” гэх мэт тогтсон үг хэллэг бий болж, тэрхүү хишиг бол “*kündü*”, “*juᠵagan*” бөгөөд, “мунхаг боолууд болвоос энэхүү хишиг харамжийг хариулах аргагүй, эзэн хаанд насан туршийн өртэй” буюу ерөөс “түүнийг хүртэх буян заяагүй”²⁴ тул энэхүү “хүнд”, “зузаан” хишгийг хүртвээс “баатарлаг гавьяа”, “өөрийн чадах бүхнээрээ хариулах”²⁵ ёстой ажээ.

Манжийн үеийн баримтуудад *abdangga fungnehen (nabčitu ergümjilel)* болон *ulhibure fungnehen (uqaᠭulqu ergümjilel)* хэмээх хоёр төрлийн өргөмжлөлийн нэр

²² Elverskog, J. *Our Great Qing*, Honolulu: University of Hawai'i Press, 2006, 69-70.

²³ Gō, M. I. de Rachewiltz нар (эмх.) *SaghangSečen'sErdene-yin Tobči*, Australia: Australian National University Press, 1990, 188-189 [95v04-95v09].

²⁴ Atwood, C. “Worshipping Grace”: The Language of Loyalty in Qing Mongolia,” *Late Imperial China*, vol. 21, no. 2, 2000, 5.

²⁵ Atwood, C. “Worshipping Grace”: The Language of Loyalty in Qing Mongolia,” *Late Imperial China*, vol. 21, no. 2, 2000, 6.

гардаг.²⁶ Эдгээр нь ойролцоогоор 410 см урт, 32 см өргөн улаан-хөх-хар-цагаан-шар өнгийн торгоор бүрхсэн зузаан муутуу цаасан дээр манж, хятад, монгол хэлээр бичигдсэн байх ба тус бүр нь 82 см өргөн тус тус хэсгүүдэд хуваагдах аж. Улаан, цагаан, шар өнгийн хэсэгт хар бэхээр бичих бол хөх, шар хэсэгт нь улаан бэхээр бичих ажээ. Үүнээс гадна үе улиран хэргэм залгамжлах өргөмжлөлийн эхний хэсэгт байгуулсан гавьяа зүтгэлийг нь тодорхой бичих ба дараа дараагийн хэсгүүдэд хэргэм залгамжлагчийн зөвхөн нэр, залгамжлах хэргэм болон он сарыг л тэмдэглэх аж.²⁷ Өргөмжлөлийн захыг хөх, улаан өнгө оролцсон луу болон үүлэн хээгээр чимэглэх бөгөөд Үндэсний түүхийн төв архивт хадгалагдан буй монгол ноёд язгууртнуудад олгосон өргөмжлөлүүд ч дээрхтэй адил ойролцоо хэв загвартай.²⁸

Дээд зэрэг зиндааны ноёд язгууртнуудад хэргэм, цол шагнахад тэдний эх эцэг болон авааль болон анх дараа авсан хатад эхнэрийг нь мөн дагуулан цол өргөмжилдөг бөгөөд судлаач Франке, “эхнэрийн өргөмжилсөн цолыг нөхрийн өргөмжлөл дотор хамт бичдэг” уламжлал ч байсан тухай дурдсан байдаг.²⁹ Энэхүү өгүүлэлд ашигласан Үндэсний түүхийн төв архивт хадгалагдан буй баримтууд нь Тэнгэрийн тэтгэсэн хааны 4-р оноос (1739) Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын эхэн үеийг хамрах (1914-1915) бөгөөд эдгээр нь Чингийн төрөөс монголын язгууртан эмэгтэйчүүдэд олгож байсан цол, өргөмжлөлтэй холбогдох журам, олгох явц, шат дамжлага зэрэг өргөн мэдээллийг агуулжээ.

Юун түрүүн Чин улсын үед монгол язгууртан ноёдын эхнэрийг нөхрийн хэргэм зэргийн дагуу цол өргөмжлөх тухай, “*toḡtaḡaḡsan qauli-dur qatun fuḡin ergümjilel-i gūyūqui anu urida gūyūn debsigūlkū baḡuragūlqui anu öber öber-ün er-e-yin kergem-i daḡamui*” хэмээн тэмдэглэсэн байна.³⁰ Үүний дагуу 1760 онд [ТТ 24

²⁶ *abdangga* хэмээх нь хуудас бүхий, аккордион мэт эвхэгддэг мөн *ulhibumbi*-ийг тайлбарлах, тодруулах, нийтэд зарлах хэмээх утгатай. *fungnembi* хэмээх үйл үг нь олгох, шагнах бөгөөд *fungnehen* гэвэл шагналыг баталгаажуулах баримт буюу батламж, угсаа гарвалыг батлах гэрчилгээ. *abdangga fungnehen* (Хятад хэлний *feng*) гэдэг нь шар юм уу алтан шар өнгийн цаасан дээр бичсэн эзэн хааны зарлиг. *ulhibure fungnehen* гэвэл тавдугаар зэрэглэл буюу түүнээс дээш зиндааны албанд томилогдож буй түшмэдүүдэд олгодог батламж. Norman, J. *Comprehensive Manchu-English Dictionary*, Cambridge: Harvard University Asia Center Press, 2013, 1; 125; 389.

²⁷ Franke, W. “Patents for Hereditary Ranks and Honorary Titles during the Ch’ing Dynasty,” *MonumentaSerica*, Vol II fasc. 1/2 (1942), 44-46.

²⁸ МУУТА, М-168, Д№2 ХН№815; МУУТА, М-162 Д№2 ХН№338a; МУУТА, М-25 Д№1 ХН№12a.

²⁹ Franke, W. “Patents for Hereditary Ranks and Honorary Titles during the Ch’ing Dynasty,” *MonumentaSerica*, Vol II fasc. 1/2 (1942), 55.

³⁰ МУУТА, М-9 Д№3 ХН№8166-89 Энэхүү баримт нь Бадаргуулт төрийн 30-р он буюу 1905 онд хамрагдана.

он] чин ван Чивагаримпилээс³¹ өөрийн хатан Гүмүдэд цол өргөмжлөхийг хүсэн дараах бичигт,

bayıcağabasu wang minu bye-e-yi gյüin wang yabuqui-dur minu qatun Gümada altan nabçitu ergümjilel ologsan. edüge bogda ezen örösiyen qoşoi çin wang bolğagşan-u tula yağakibası jokıqu yabudal-i jangjun qoşoi çin wang törö-yin efü tan-u gajar-aça sidken jıgajı ajiyamu kemekü-eçe gadan-a minu qatun-u obuğ inu batud obuğ-tai-yi medegülün egün-ü tula ergübe³² хэмээжээ.

Холбогдох баримтуудаас үзэхэд, *çin wang*-ийн эхнэрт *qosoi qatun*, *jüin wang*-ийн эхнэрт *törö-yin qatun*, *beyile*-ийн эхнэрт *törö-yin beyile-yin qatun*, *beyise*-ийн эхнэрт *qosıgün-u beyise-yin qatun*, *güng*-ийн эхнэр *noyaqan* хэмээх цол шагнан өргөмжлөл олгодог байсан нь ихэд түгээмэл байна. Харин Навчит өргөмжлөл, Ухуулах өргөмжлөл хоёрыг тухайн хатны цолоос хамаарч олгож байсан уу гэсэн асуултад хариулахын тулд 1904 онд [БТ 29 он] хамрагдах нэгэн баримтыг дурдвас,

tüsiyetü qan ayimağ-un jasağ törö-yin gյüyin wang anangdawaçir-un³³ abalı qatun jeleme ölyinsaçal obuğ. tüsiyetü qan ayimağ-un jasağ qosıgün-u beyise puncüğçerin-ü³⁴ abalı fü jin au obuğ. egünce degegsi gյüyin wang qatun nige beyise fü jin nige bürin-e nabçitu ergümjilel-i olğagulbası jokimui. tüsiyetü qan ayimağ-un ulus-un tüsiy-e güng-ünjerge jasağ ulus-tur tusalağçi güngçedengsonom-un³⁵ abalı fü jin dolod obuğ. tüsiyetü qan ayimağ-un jasağ ulus-tur tusalağçi güng misıgdorji-yin³⁶ abalı füjin qangçui obuğ. egünce degegsi ulus-tur tusalağçi güng-ün fü jin qoyar burin-e uqağulqu ergümjilel-i olğagulbası jokimui³⁷

Мөн засаг, улсад туслагч гүн Мишигдоржийн эхнэр 1896 онд *Ухуулах*

³¹ Цэрэндорж, Ц нар (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 19. Илтгэл шастирын 32 дугаар дэвтэрт өгүүлснээр, тэрээр ТТ-ний 12-онд засаг төрийн жүн ван залгамжилсан бөгөөд “тулгар тэрсэлсэн хулгай самуурсны хирд шаламгайгаар баатархан хулгай лугаа байлдаж яаран Бандийг өмөглөн тусалсны ... хишиг хүртээж хошой чин ван дэвшүүлж өргөмжлөөд ... Дөчин хоёрдугаар онд үгүй болбой.

³² МУУТА, М-10 Д №2 ХН №370-17.

³³ Монголын түүхийн тайлбар толь. Түшээт хан аймгийн Мэргэн засгийн хошуу, засаг төрийн жүн ван [1892-1912]. <https://mongoltoli.mn/history/h/591>

³⁴ Монголын түүхийн тайлбар толь. Түшээт хан аймгийн Дархан засгийн хошуу [1884-1923]. <https://mongoltoli.mn/history/h/591>

³⁵ Монголын түүхийн тайлбар толь. Түшээт хан аймгийн Бишрэлт засгийн хошуу [1858-1908]. <https://mongoltoli.mn/history/h/591>

³⁶ Монголын түүхийн тайлбар толь. Түшээт хан аймгийн Сэцэн засгийн хошуу [1875-1906]. <https://mongoltoli.mn/history/h/591>

³⁷ МУУТА, М-9 Д №3 ХН №8166-5.

өргөмжлөл³⁸, бэйл Цэвдэнгийн эхнэрт 1740 онд *Алтан навчит өргөмжлөл*³⁹, засаг улсын түшээ гүн Сономванчигийн эхнэрт 1815 онд *Ухуулах өргөмжлөл* ⁴⁰, жүн ван Юндэндоржийн эхнэр төрийн гэгэд 1787 онд Навчит өргөмжлөл⁴¹ гүн Цэдэндоржийн эхнэрт мөн Ухуулах өргөмжлөл⁴² тус тус олгосон ба 1760 онд [ТТ 24 он] чин ван Чивагяримпилээс түүний хатан Гүмүдэд, “*čibağyarimpil namayi čing wang bolğagšan-u qoyin-a minu qatun gümüda-dur čing wang-yin qatun-u altan nabčitu ergümjilel*”⁴³ олгуулахыг хүсэн өргөж байжээ. Үүнээс харахад, чин ван, жүн ван, бэйл, бэйсийн авааль эхнэрт Навчит өргөмжлөл, улсын түшээ гүн, улсад туслагч гүнгийн авааль эхнэрт Ухуулах өргөмжлөл голдуу олгож байсан мэт. Гэхдээ энэ асуудлыг цаашид судлах шаардлагатай.

ГМТЗЯЯ-ны хууль зүйлийн бичигт язгууртан эмэгтэйчүүдэд өргөмжлөл олгох тухай заалтад [23.9. 801]:

Өргөмжилсөн дотоод гадаад засаг хан вангийн хатан, бэйл бэйсийн ноёхон, тайж тавнангийн гэргий нар жич гэг нарт олгуулбаас зохих навчит өргөмжлөл олгуулах зарлигийг Журганаас харьяат чуулганы даргад хүргүүлж уламлан тархаан олгуул. Түшмэл гаргаж хүргүүлэхийг хэрэгсэхгүй болгуул. Олон харьяат чуулганы дарга хүлээн авсан навчит өргөмжлөл олгуулах зарлигийн тухай өдөр, жич уламлан тархаан өгсөн, хурааж авсан өдрийг ялган салгаж тодорхойлон гаргаж Журганд мэдүүлэн хянан байцаагтун. ⁴⁴

Мөн 1810 он [СЭ 14]-ы дараах баримтад,

*bayiçağabasu qauli-dur gadağadu qatud beyile beyise güng-ün gergei-ner qoşoi geg törö-yin gege beyile-yin ökin törö-yin gege qosigun-u gege güng-ün ökin gege-ner tabun jil alusulağad man-u jurgan-aça quriyangguylju ayiladqağad ergumjilmüi*⁴⁵

хэмээх эдгээр журмын дагуу таван жилд нэг удаа Ёслолын явдлын яамнаас өргөмжлөл олгох хугацааг тодорхойлон зарласны дараа аймгийн чуулган даргын газраас өргөмжлөл олгох хатад эмэгтэйчүүдийн цэс үйлдэж хураангуйлан ГМТЗЯЯ-д илгээн, ГМТЗЯЯ-аас Ёслолын явдлын яам хүлээн авч хаанд өргөн барьдаг байжээ.

³⁸ МУУТА, М-31 Д №2 ХН №4194-53.

³⁹ МУУТА, М-10 Д №2 ХН №370-8.

⁴⁰ МУУТА, М-9 Д №3 ХН №1534-7.

⁴¹ МУУТА, М-9 Д №3 ХН №644-2.

⁴² МУУТА, М-9 Д №3 ХН №644-2.

⁴³ МУУТА, М-10 Д №2 ХН №370-25.

⁴⁴ Чимид, Б нар. (эмх.) *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл /1206-1910/,* Боть1, Улаанбаатар, 2010, 410.

⁴⁵ МУУТА, М-9 Д №3 ХН №1534-24.

ГМТЗЯЯ-аас өргөмжлөл хүсэх хатад эмэгтэйчүүдийн цэсийг ирүүлэх эл ажлыг эхэн үедээ Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжны газраас ерөнхий хариуцан дөрвөн аймгийн чуулган даргын газраар дамжуулан гүйцэтгэж байсан бол 1756 оноос Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын газар мөн оролцох болсон байна.⁴⁶

Өргөмжлөл олгох хатад, эмэгтэйчүүдийн цэсэд тэдний нэр, ургийн овог, овог, тухайн ноёны эхнэр болон очсон өдөр, сар, жил, авааль эхнэр, дараа авсан эхнэр, мөн дараа авсан эхнэр бол анх дараа авсан, анх авсан эхнэр нь өргөмжлөл хүртэж байсан зэрэг мэдээллийг, "... *basa kü darağ-a abuğsan noyaqan kemekü anu angq-a darağ-a abuğsan abqai esebesü dakin darağ-a abuğsan kerebe angq-a darağ-a abuğsan bolbasu abali ergümjilel abuğsan esigsen...*"⁴⁷ хэмээн тодорхойлон бичиж чуулган даргын газраа явуулдаг байв.

Тухайн цэсэд орох ёстой мэдээлэл дутуу, буруу зөрүү болвоос өргөмжлөл олгохыг байлган дараа өргөмжлөл олгох хугацаа хүртэл хойшлуулах тохиолдол байжээ. Жишээ нь засаг түшээ гүн Сономдаржаагийн⁴⁸ нояхан Дэлгэр 1825 онд [ТГ 4 он] өргөмжлөл олгуулахаар хүссэн ч мэдээлэл дутуу, тодорхой бус шалтгаанаар 1835 он [ТГ 14 он] хүртэл олгогдоогүй талаар баримтад өгүүлсэн байдаг.⁴⁹ Мөн түүнчлэн бэйсийн зэрэг, засаг улсад туслагч гүн Цангилигдоржийн нояхан Сайнбуян нь 20 насандаа түүний анх дараа авсан эхнэр болон ирсэн бөгөөд 1870 онд [БЗ 8 он] өргөмжлөл авахаар хүсэлт гаргасан боловч дараа 1875 [БЗ 3 он], 1880 [БТ 5 он] 1884 [БТ 9 он], 1885 (БТ 10 он) болон 1886 он [БТ 11]-уудад удаа дараа хүсэлт илгээсний дараа 40 насандаа 1886 онд өргөмжлөл авчээ.⁵⁰ Үүнээс харахад, өргөмжлөл олгох үйл явц олон жилээр хүлээгдэх тохиолдол ч байжээ.

Мөн түүнчлэн өргөмжлөлийг эр нөхөр нь нас барсны хойно олгох тохиолдол байв. Энэ нөхцөлд, эцгийн хэргэм зэргийг хууль ёсоор залгамжлан авсан хүү болон түүний эхнэр шинээр цол өргөмжлөгдөхөд хадам эх нь бэрийн хамтаар өргөмжлөл хүсч болох тухай Бадаргуулт төрийн 30-р он (1905)-ы зарлигт, "*gadağadu mongğol törö-yi jasaqu yabudal-un yamun-aça mongğol qan wang beyile beyise güng-ün qatun fūjīn-nar-tu olğagulqu*

⁴⁶ МУУТА, М-10 Д №:2 ХН №:370-13, М-31 Д №:2 ХН №:71-7, М-31 Д №:2 ХН №:950-7.

⁴⁷ МУУТА, М-31, Д№ :2, ХН № :4193-53 Энэхүү баримт нь Бадаргуулт төрийн 21-р он буюу 1896 онд хамрагдана.

⁴⁸ Монголын түүхийн тайлбар толь. Сэцэн хан аймгийн Эрхэмсэг засгийн хошууны засаг ноён [1822-1844].<https://mongoltoli.mn/history/h/591>

⁴⁹ МУУТА, М-31 Д№:2 ХН№:1134-10.

⁵⁰ МУУТА, М-31 Д№:2 ХН№:3449-2. Энэ талаар баримтад, *burintü jasağči-yin naimaduğar on, arban ġurbaduğar on, badarğultu törö-yin tabuduğar on, yisüdüger on, arbaduğar on-du ergümjilel olğagulqu-i erejü darağ-a udağ-a ċiğulğan-u daruğ-a tan-a ergün medegülügen bolbaču, yerü ene jabsar ergümjilel olğaguluğsan ügei, хэмээжээ.*

*ergümjilel-yi nasu önggeregsen jasağ-yin qatun fūjin-yin ergümjilel-yi tegünü köbegün jerge jalgamjilağsan qoyin-a beri-lüg-e qamtuda gūyusugai kemekūjerge tusiyağsan*⁵¹ хэмээжээ.

Өргөмжлөл олгох хааны зарлиг бичгийг Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайдын газраас Чуулган даргын газраар дамжуулан засаг ноёдод мэдэгдэх бөгөөд тухайн ноён өөрийн зардлаар өргөмжлөл авч ирэх тусгай албаны хүнийг ГМТЗЯЯ-наа илгээдэг байсан бол⁵² Тэнгэрийн тэтгэсний 40-р он (1776)-оос энэхүү үйл явц нь өртөг өндөр тул тусгай албаны хүн явуулахыг байлгасан зарлиг гарч байжээ.⁵³ Байгалийн бэрхшээлээс болж үгүйрч хоосорсон ардууд тухайн хошууны ноёны хатанд олгосон өргөмжлөлийг хүлээн авчруулах зардлыг гаргаж дийлэхгүй олон жил удсан тухай нилээдгүй баримт таарч байгаагаас харахад тэрхүү зардлыг хошууны энгийн ардуудаас гаргадаг байсан нь илэрхий байна.⁵⁴

Судлаач Этвүүдийн тэмдэглэсэнчлэн, Чингийн төрөөс өндөр хишиг хүртсэн ноёдыг зуурнууд эзэн хаанд талархсанаа илэрхийлэн тэр хүнд их шанг хүртэх “буяан заяагүйгээ” илэрхийлж эзэн хааны зүг мөргөх зэрэг тусгай зан үйл хийдэг байсан уламжлалын адил⁵⁵ цол өргөмжлөл хүлээн авсан хатад ч мөн, “*ejen-ü altan yamun jüg yosulal ġurban-ta sögödċü yisün üy-e mörgüged kisig kürtejü küliyen abuğsan*”⁵⁶-ыг тэмдэглэн ёслол үйлдэж, мөн “*qoşoi qatun aqai-tan-a ergümjilel olğaguluğsan jerge uċir-tu esergün jil bayar yoslol güyicedkekü tuqai soyorqal-i ayiladqaju ene naiman sara-yin arban yisün-düġurban bağ-a nasun-u morin uruldağulju, ċöken böke barildağulun, sur qarbuqu-bar nigengte tölöblen toğtağsan*” зэрэг бэсрэг наадам ч хийдэг байжээ.

Бадаргуулт төрийн 21-р он (1896)-ы дараах баримтад язгууртан ноёдын охидыг цол өргөмжлөх тухай заалт байх агаад, чин вангийн авааль хатнаас төрсөн охиныг хошой авхай (hoşoi gege), чин вангийн бага хатан, жүн вангийн авааль хатан болон бэйлийн эхнэрээс төрсөн охиныг төрийн авхай (doroı gege), жүн вангийн бага хатан, бэйсийн төрсөн охиныг хошууны авхай (gusai gege) хэмээгээд güng-ийн охидыг гүнгийн авхай (gung ni jui gege) цол олгохоор заажээ.⁵⁷ Энэхүү баримтаас

⁵¹ МУУТА, М-9 Д№3 ХН№8166-2.

⁵² МУУТА, М-9 Д№4 ХН№1952-1.

⁵³ МУУТА, М-9 Д№3 ХН№290-1.

⁵⁴ МУУТА, М-9 Д№3 ХН№4414-6.

⁵⁵ Atwood, C. “Worshiping Grace”: The Language of Loyalty in Qing Mongolia,” *Late Imperial China*, vol. 21, no. 2, 2000, 5.

⁵⁶ МУУТА, М-9 Д№4 ХН№232-1.

⁵⁷ МУУТА, М-31 Д№2 ХН№4193-53. bayiċagabasu, qauli-dur ċin wang-un abali daray-a qatun-u törögsen keüken-i qoşoi abqai ergümjilel olğagul bağaqan qatun-u törögsen keüken beyile-yin köbegün törö-yin abqai ergümjilel olğagul ġjün wang-yin abali daray-a qatun-aċa törögsen keüken törö-yin abqai ergümjilel olğagul bağaqan qatun-u törögsen keüken qosiyun-u abqaiergümjilel olğagul naiman

харахад, язгууртнуудын төрсөн хөвгүүн охид ямар цол олгох нь тухайн хүүхдийн эхийн байр сууриас хамааралтай, эх нь тухайн ноёны авааль эхнэр бол төрүүлсэн үр хүүхэд нь өндөр цол өргөмжлөл олгох зүй тогтолтой байсан бололтой. Харин “*basa bayičagabasu, udağ-a darag-a-yin quriyangguyuilju ergümjilel olğaguluğsan dangsa čwswi-dür gağčakü dotoğadu ayimağ-un uğsağ-a abqai-yi bağulğan ögčü ergümjilegsen anu bui.gadağadu ayimağ-un wang güng-ün keüken bağulğan ögügsen qoyin-a ergümjilel čwswi sidkegsen qağučin kereg ügei böged qauli-dur mön tusağai jığağsan jüil ügei*”⁵⁸ хэмээнээс харахад лав 1896-аад оны үеийн барагцаагаар Халх болон бусад гадаад монголын язгууртнуудын охидод өргөмжлөл өгөх явдал харьцангуй ховор байсан мэт.

Монгол язгууртан эмэгтэйчүүд нөхрөөс салсан, бие өвчтэй, насан өндөр болсон эсвэл нас барсан тохиолдолд өргөмжлөлөө ГМТЗЯЯ-д эргүүлэн өгөх ёстой талаар Тэнгэрийн тэтгэсний 24-р он (1760)-д хамрах дараах баримтад,

čebden minu bey-e beyile aqui čağ-tur minu yeke qatun rabjur-tur tngri-yin tedkügsen-ü dörbedüger on jun-u segül sara-yin sine-yin naiman-a altan nabčitu ergümjilel olğağsan-ača qoyin-a minu bey-e beyile-yi bayilğağsan-ača qoyin-a altan nabčitu oluğsan qatun-u bey-e ketüregsen böged urida-yin olğağsan nabčitu ergümjilel-i qoyisi jurgan-dur tusiyagsan ügei-yi⁵⁹

хэмээх буюу “*wang minu törö-yin qatun-i ügei boluğsan-u tulada tegün-ü ergümjilel-ün q’oaming-yi ... yeke jurgan-dur ergün kürgegülügsen bölöge*”⁶⁰ мөн “*törö-yin qatun čeringdulma nayan nasun-dur kürčü qağučin арагаг ebedčitei učir-a uğ ergümjilel-i qoyisi ergüjüčibağanča bolsuğai kemegsen-i jığaqu-i erejü*”⁶¹ зэрэг өргөн мэдүүлсэн баримтууд олонтаа таарч байгаас илэрхий байна.

Ийнхүү Чин улсын үед гавьяа байгуулсан ноёд түшмэд болон цэргийн зүтгэлтнүүдийг сайшаан, цол хэргэм шагнах тогтолцоо боловсронгуй болохын сацуу тэдний эхнэр, охидод олгох цол, өргөмжлөл тогтолцоо ч төлөвшин тогтнож, хатад эмэгтэйчүүд нийгмийн давхаргын тусгай ангилалд багтан түүндээ тохирсон тусгай шалгуур үзүүлэлтийг хангаж чадсанаар цол, өргөмжлөл хүлээн авах хууль эрхзүйн орчин бий болжээ. Тэрхүү шалгуур үзүүлэлт нь тэдний ёс зүйтэй холбогдох бөгөөд энэ талаар доор өгүүлнэ.

qubi-dur oroguluğsan-ügei güng-ün abali em-e-yin törögsen aqamad keüken güng-ün köbegün abqai ergümjilel olğağul basa aliba beyile-eče dorogsi abali-ača törögsen keüken-eče nigen kümün-dür ergümjilel olğogulsuğai. busud ülegsen keüken-ner ergümjilebesü bolqu ügei kemejügüi.

⁵⁸ МУУТА, М-31 Д№2 ХН№4193-53.

⁵⁹ МУУТА, М-10 Д№2 ХН№370-8.

⁶⁰ МУУТА, М-32, Д№2 ХН№297.

⁶¹ МУУТА, М-31, Д№1 ХН№1197.

3. Чингийн төрөөс хатадад олгож байсан өргөмжлөлийн нийгмийн ёс суртахуунд нөлөөлөх нь

Чин улсын үед хатад, эмэгтэйчүүдэд цол өргөмжлөх эрхзүйн орчин бүрэлдэн тогтсоноос гадна цол өргөмжлөлт хатад эмэгтэйчүүд нийгмийн өмнө үүрэг хариуцлага хүлээх болж, тэд эмэгтэй хүний дэвшилтэт ёс суртахууныг нийгэмд үлгэрлэх ёстой ажээ.

Чингийн төрөөс эмэгтэйчүүдийн ёс суртахууны талаар явуулсан бодлого нь Күнзийн сургаалтай холбоотой. “Үзэхүйд тод тунгалаг, сонсохуйд сод мэргэн, харах царай эелдэг, хандах дүр хүндлэлтэй, хэлэх үг үнэнч, хэрэг үйл хичээнгүй, эргэлзвээс асуух, уурлаваас уршгийг нь санах, олз ашиг орвоос ёс журмыг бодох”⁶² чанарыг өөрийн ёс суртахууны гол зарчим болгох нь зөв хүн болон төлөвших тухай ойлголтыг бүрэн тодорхойлж буй гэлтэй.

Чин улсын үед хатадад олгож байсан өргөмжлөлд зориулан зохиосон эхийг судлан үзвээс дээрх үндсэн санаа яв цав таарч байна. Жишээ нь, Энх-Амгалангийн 45-р он (1706)-д хамрагдах дараах эх болвоос Горлос аймгийн улсад туслагч гүн Батын⁶³ гэргийд олгосон өргөмжлөлийн зохиосон эхэд,

tngri-yin ibegel-iyer čağ-i ejelegsen

quwangdi-yin jarlig. wang-un deü boluğad. öbetegsi-yi kürtegүlkү-yin tula. kisig-i tarağaqui-dur jerge bui. dotoğadu keb-i töb bolğaju. jerge-yi inu üjejү bolğaqu-yin tula. sayin-i ergүmјilekүi-dүr ilğaqu ügei. mağad-iyar törө-yin čimeg-dүr ilğabasu. kesig jarlig-i kürtegүlkү anu jокistai bui. ğorlos-un ulus-tur tusalağči güng batu-yin gergei-yin obuğ anu qowalgiyan. činu törölki kičiyenggүi takimdağu. erdem inu dölgen töbsin. öğör-tegen tusalaju. ger-tүr-iyen keb bayiğulju. jasaqu tegsilekүi-dүr soyol-i tegүsejү. dotonağur ebün tusalağsan anu mağad-iyar olan. teyin čimayi ulus-tur tusalağči güng-ün üneger em-e ergүmјilejү. g'aoming ögbe. güng-dүr qolbağsan anu. öbtegsi niğurtai inu qoyar ügei. takiqu takil-i arigulan takimdaqu-be kičiyekү-yi uriddbasu jокimu. öbetegsi bolba kemen büü omorqağtun. kesig-i küliyebe kemen büü tasigurağtun. kičiyegtүн.⁶⁴

⁶² Кунз, *Шүүмжлэлт өгүүлэл*. Хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ, Улаанбаатар: Адмон, 2013, 156.

⁶³ Цэрэндорж, Ц нар. (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 169. Илтгэл шастирын зургадугаар дугаар дэвтэрт өгүүлсэнээр, “Энх-Амгалангийн дөчин хоёрдугаар он (1703) засаг улсын түшээ гүн залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний тавдугаар онд (1741) үгүй болсны хойно түүний хөвгүүн Доржид залгамжлуулбай” хэмээжээ.

⁶⁴ Буяндэлгэр, Ж нар. (эмх.) *Dayičing gürün-ü dotoğadu yamun-u mongğol bičig-ün ger-ün dangsa*, Боть18, Kökeqota: öbör mongğol-un yeke surğağuli-yin mongğol sudulul-un dededү surğağuli, 2005, 26-28 [0011-0013]. gung-ni qooli. abahaiheseforgon be aliha.quwangdihesese wang niilhiofi. wesihun be isibure be dahame. kesi be. selgiyere-de jergi bi. dorgidoron be tobofi. jergi be tuwameobure

Энэхүү эхийн доторх “...*törölki kičiyenggüi takimdağu. erdem inu dölgen töbsin. ögör-tegen tusalaju. ger-tür-iyen keb bayigulju. jasaqu tegsileküi-dür soyol-i tegüsejü. dotonağur ebün tusalagsan anu mağad-iyar olan... takiqu takil-i arigulan takimdaqu-ba kičiyekü-yi uriddbasu jokimu.öbetegsi bolba kemen büü omorqağtun. kesig-i küliyebe kemen büü tasigurağtun. kičiyegtün*” хэмээх мөрүүдийг Күнзийн сургаалын эш онолд тулгуурлан тайлбарлаж болохоор байна.

Эгэл олныг ууч өгөөмөр сэтгэлээр энэрэн хайрлах, асарч тэтгэх, ялангуяа эцэг эхийн ачийг хариулахад (*filial piety*) хичээнгүй, тахимдуу (*činu törölkikičiyenggüi takimdağu*) явж, “*takiqu takil-i arigulan takimdaqu-be kičiyekü-yi uriddbasu jokimu*” хэмээн эцэг эхийн ачийг хариулахын чухлыг дээрх эх бичвэрт өгүүлсэн байна. Эцэг эхийн ачийг хариулах тухай сураалд,

*Өвөг дээдсийн сүмийн тахилга дор өөрийн сууринаа зогсож, дээдсийн уламжилсан мөргөлийг үйлдэн, дээдсийн үеийн хөгжмийг үүсгэн, дээдсийн эрхэмлэж асныг эрхэмлэн, дээдсийн хайрлаж асныг хайрлан, өөд болж үрэгдсэн нь эдүгээ амьд сэрүүн лугаа адил, өнгөрөн одсон нь эдүгээ орших лугаа адил байх аваас ачлалын дээд туйл тэр буюу.*⁶⁵

Эмэгтэйчүүдэд зориулсан ачлахуйн ёсны сургаал зохиолд (*Nü Xiaojing-The Book of Filial Piety for Women*)-д⁶⁶ “хадам эцгээ өөрийн эцэг мэт хүндлэх, хадам эхээ өөрийн төрсөн эх мэт хайрлах ба үүнийг хичээн гүйцэтгэх нь үүрэг хариуцлага бөгөөд даган биелүүлэх нь ёслол”⁶⁷ хэмээн өгүүлэх нь нөхрийн талын ураг төрөлд ээлдэг нинжин сэтгэлээр хандах, эцэг эхийн амьд сэрүүн үед асран энэрч, насан өөд болсны хойно онгон шүтээнд нь тавиг тахилыг таслахгүй байх уламжлалтай холбогдоно.

Эрдэм нь дөлгөөн түвшин (*erdem inu dölgen töbsin*) байх талаар, Күнзийн сургаалын “Хэв дундын ёс”-д амгалан төвшин бус хэмээх нь аюул ослыг дагуулдаг тул “Чин үнэнч чигч шударгуу явагтун”⁶⁸ хэмээсэн байдаг. Энэ нь төрийн түшээ,

be dahame. sayin be dengnere de ilgaraqu. yargiyan-idoroimiyamigan-teacanaci. kesihese-be isiburegeyen. gorlos-igurun-de ayisilara gung batu-isargan-ihalagowalgeyan. sinibaninggunolhoba. erdemtu min.ukennemeyenigen-de tayisilame boo -de turuniligufi. dasarataksilerefe-be yongkiyafi. dorgidurayisilahanggeyariyan-iambule. tudtusimbegurun-de ayisilara gung-niunenggihefungnefi. g'aomingbuhe. gung-de holbohonggewesihunderengejuruuqu. fuktureemesun-be bolgomile. hiyoošungingun be nedeciacambi. wesihun oho seme umecokoloro. hese be aliha seme umedabašara. gingguleelhetayifun-idehisunjacianiyaforgonbiyajuwenadan da.

⁶⁵ Зы Си. *Хэв дундын ёсон*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ Улаанбаатар: Адмон, 2013, 51.

⁶⁶ Mann, S., Yu-Yin Cheng. *Under Confucian Eyes*. University of California Press: Berkley, 2001, 48. 730 оны үед Miss Zhen-ий зээ дүүгээ хадамд гарахад нь бичсэн Эмэгтэйчүүдийн ачлахуйн ёсны тухай ном (“The Book of Filial Piety for Women” буюу *Nü Xiaojing*) ажээ.

⁶⁷ Mann, S., Yu-Yin Cheng. *Under Confucian Eyes*, University of California Press: Berkley, 2001, 53.

⁶⁸ Зы Си. *Хэв дундын ёсон*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ Улаанбаатар: Адмон, 2013, 22.

ерөөс эр хүний баримтлах гол зарчим бол дөлгөөн түвшин, ууч тэнүүн, ээвэргүү зөөлнөөр бусдыг сургах⁶⁹ бол олон ардад ээл энэрэлтэй, шударга үнэнч байх эрдмийг төрийн хатан хүн эзэмших ёстой ажээ.

Күнзийн суртал эхэн үедээ хүйсийн нарийн ялгаа байгаагүй боловч XII зууны үеэс шинэ урсгалууд дэлгэрч,⁷⁰ ялангуяа эмэгтэйчүүдэд зориулсан ачлахуй, цэвэр ариун явдлыг сургасан сургаал зохиолууд бий болжээ.⁷¹ Тэдгээрт эмэгтэй хүний сахих зургаан төрлийн чанарыг 1. Шулуун шударга зан, 2. Цэцэн мэргэн ухаан, 3. Ачлал, энэрэлтэй байх 4. Бишрэл, хүндлэлийг дээдлэх 5. Цэвэр ариун явдлаар нийцэл зохиролтой байх 6. Уран цэцэн ухаан болно⁷² хэмээн сургасан нь эмэгтэйчүүдэд зориулсан дараа дараагийн сургаал зохиолуудын эх үндэс болсон байна.⁷³

Улмаар гэр бүлийн амьдралд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарь тусдаа болж, эмэгтэйчүүд “гэрийн доторх үйл”(nei)-ийг эрхлэх, харин эрэгтэйчүүд “гэрээс гарч төрийн үйл” (wai)-ийг эрхлэх⁷⁴ ёстой гэсэн санаа бий болсон. Эмэгтэй хүн гэр бүлийн “дотоод” аж байдлыг эрхлэхийн сацуу эр нөхөртөө үнэнч туслагч нь байж тэдний “гадаад” үйлд зөвлөх, түшиг болох тухай суртал, сургаал дэлгэрсэн нь⁷⁵ язгууртан эмэгтэйчүүд илүү хамрах бөгөөд тэд ёс журмыг бусдаас өндөр түвшинд баримтлах ёстой болжээ.

Сүн улсын үеийн Күнзийн сурталтан Жу Ши (Chu Hsi, 1130-1200) “Их суртахуй”-г нэмж нөхвөрлөн, тайлбар хийж үлдээсэн ажээ.⁷⁶ Энэхүү “Их суртахуй” (“Learning of the Way” (*Tao-Hsüeh*) хэмээх урсгалын гол үзэл санаа нь “өөрийн биеийг засаад өөр бусдыг тохинуулахуй ёсон”, “алив хүмүүний ёс

⁶⁹ Зы Си. *Хэв дундын ёсон*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ Улаанбаатар: Адмон, 2013, 39.

⁷⁰ Birge, B. *Women, Property, and Confucian Reaction in Sung and Yüan China (960-1368)*, Cambridge: Cambridge University Press, 2002, 25-26. Neo-Confucianism-ын гол төлөөлөгч болох Chu Hsi (1130-1200) Learning of the Way (*Tao-Hsüeh*) хэмээх шинэ урсгалыг дэлгэрүүлсэн. Энэхүү урсгалын гол санаа болвоос хүн өөрөө өөрийгөө хөгжүүлэх тухай бөгөөд энэ нь ёс суртахуунд хүрэх гол зам хэмээх сургаал юм.

⁷¹ Rosenlee, Li-Hsiang Lisa. *Confucianism and Women*, State University of New York Press: Albany, 2006, 97.

⁷² Rosenlee, Li-Hsiang Lisa. *Confucianism and Women*, State University of New York Press: Albany, 2006, 97.

⁷³ Rosenlee, Li-Hsiang Lisa. *Confucianism and Women*, State University of New York Press: Albany, 2006, 96.

⁷⁴ Birge, B. *Women, Property, and Confucian Reaction in Sung and Yüan China (960-1368)*, Cambridge: Cambridge University Press, 2002, 27.

⁷⁵ Birge, B. *Women, Property, and Confucian Reaction in Sung and Yüan China (960-1368)*, Cambridge: Cambridge University Press, 2002, 29.

⁷⁶ Зэнз. *Их суртахуй*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ Улаанбаатар: Адмон, 2013, 19.

суртахуй төлөвшихүйн эх язгуур нь “биеийг засахуй”-д орших” явдал юм.⁷⁷ Дээрх өргөмжлөлд дурдагдаж буй “*ögör-tegen tusalaju*”-өөрөө өөрийгөө боловсруулан, ёс суртахууныг дээдэлснээр, “*ger-tür-iyen keb bayigulju*”-хэв ёсыг байгуулан гэрээ засах нь эмэгтэй хүний гэр бүлийн “дотоод” үйлийг эрхлэх үндсэн зам (path or way)⁷⁸ мөн хэмээсэн санаа болно. Күнзийн сургаалийн ёсоор, “хэв дундын ёсон” хэмээх нь эс хазайхуй, эс хэлбийхүйг хэлэх бөгөөд “эс хувирахуй эс өөрчлөгдөхүйг хэв хэмээмой... хэв хэмээхүй нь тэнгэрийн дор тогтсон жам болой” хэмээн тайлбарласан байдаг.⁷⁹

Ийнхүү ёсыг даган, өөрийн биеийг боловсруулан, суртлыг сахиснаар⁸⁰ төрийн хэргийг гүйцэтгэхэд эр нөхөртөө “*dodonağur ebün tusalagsan*”эхнэр хүнийг хаан төрөөс сайшаан, хишиг хүртээх нь зүйн хэрэг хэмээх нийтлэг санааг Энх-Амгалангийн дөчин тавдугаар он (1747)-д Хорчин аймгийн засаг түшээ гүн, чин ван Арашан,⁸¹ Хорчин аймгийн хошой зоригт чин ван Бадам,⁸² Аоханы төрийн жүн ван Өлзийт,⁸³ мөн Хорчин аймгийн төрийн жүн ван Очир⁸⁴ зэрэг монгол ноёдын гэргий нарт олгосон өргөмжлөлүүдийн эх бичвэрүүдээс тодорхой харж болно.⁸⁵ Харин энэхүү их хишгийг хүртсэн хэн бүхэн бие тоон, омог бардмаар явах бус, “*öbetegsi bolba kemen büü omorqagtun*”, “*kesig-i küliyebe kemen büü tasiguragtun. kiçiyegtün*” хэмээн ёсыг гүйцэтгэн, зөв суртлыг нийгэмд үлгэр жишээ болгох, ингэснээр хаан төрд хичээнгүйлэн зүтгэх ёстой гэсэн үзэл санааг ч мөн тодруулж болно.

Дээрхтэй ижил санааг Энх-Амгалангийн дөчин долоо (1709), дөчин наймдугаар

⁷⁷ Зэнз. *Их суртахуй*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэе Улаанбаатар: Адмон, 2013, 25.

⁷⁸ Birge 2002, 25.

⁷⁹ Зы Си. *Хэв дундын ёсон*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэе, Улаанбаатар: Адмон, 2013, 27.

⁸⁰ Зы Си. *Хэв дундын ёсон*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэе, Улаанбаатар: Адмон, 2013, 29.

jasaqi- ёсыг даган биеийг засахыг гэгээрэхүй хэмээмүй, tegsileküi-dür soyol-i tegüsejü- ёслол журамд нийцэхүйг зохирол хэмээмүй.

⁸¹ Цэрэндорж, Ц нар. (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 24. Тавдугаар удаа залгамжилсан нь Арашан. Энх-Амгалангийн дөчин нэгдүгээр он мөнхүү засаг хошой Түшээт чин ван залгамжилбай. Тавин есдүгээр онд үгүй болбой.

⁸² Цэрэндорж, Ц нар. (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 26. Энх-Амгалангийн хорин долдугаар он хошой зоригт чин ван залгамжилбай. Найралт төвийн гуравдугаар онд үгүй болбой.

⁸³ Цэрэндорж, Ц нар. (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 40. Энх-Амгалангийн дөчин дөрөвдүгээр онд төрийн жүн ван залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний арван гуравдугаар онд үгүй болбой.

⁸⁴ Цэрэндорж, Ц нар. (эмх.) *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илгэл шастир*, Улаанбаатар, 2007, 29. Эээр засагчийн арван дөрөвдүгээр он засаг төрийн Засагт жүн ван залгамжилбай. Эх-Амгалангийн тавин долдугаар онд үгүй болбой.

⁸⁵ Буяндэлгэр, Ж нар. (эмх.) *Dayicing gürün-ü dotoğadu yatun-u mongğol biçig-ün ger-ün dangsa*. Боть18, Көкеqota: öbör mongğol-un yeke surğağuli-yin mongğol sudulul-un degedü surğağuli, 2005, 18-28 [0004-0013].

онуудад (1710) Энх-Амгалан хааны “*küngdū kičiyenggüi güngjü*”, “*ülemji kemjijy-e-dü olon-u güngjü*”⁸⁶ нарт олгосон цол өргөмжлөлийн эхүүдээс мөн харж болно.

Үүнд,

engke amugulang-un döčin doloduğar on. sir-a quluğan-a. ebül-ün segül sar-a-yin sin-e-yin ekin-e. qarağčın taulai. arban yisün-e ulağčın moğai edür quwangdi-yin jarlig. жоо diyen bičig-dür. yosulaжу ögkü-yi erkileged. boğda ökin ür-e-degen kičiyegtün kemen surğaжуqui. ši king bičig-dür kičiyenggüi nayiramdaqu-yi sayisiyağad. qad-un ökin ür-e-yi üjesküleng-dei kemen mağtaжуғи: dotoğ-a-du törö-yi bolbasurağulbasu. ğayiqamsig-du erkin-i kürteğülbesüjokimui. jaсаğ-un güngjü či minu ökin. sedkil činu kičiyenggüi nayiramdaqu: yabudal činu dölgen töbsin. eke-yin keb-i күндүде dağaju. surğal-i ordo qarsi-yin dotor-a ... dağuriyabai. qutuğtu-yin erdem-eče edesün ese boluğsan-u tula. mağtağdaqui anu ögör-ün ger-dür neng aldarsibai: tngri-yin ğayigaqamsig-du salburi-ača törögsen. yeke ger-dür qolbabai. ioi diy-e bičig-ün sidar түрүл-үн tula. degedü olon-dur qamtubar tusalamui: sayin qolboğ-a jokiyağsan-iyar yosutu debel-i öğbesüjokimui. teyin čimayi edüge tusalaжу күngdū kičiyenggüi güngjü kemen ergүjү.altan čwi bičig soyorqabai. öčүken sedkil-iyer дүгүрeнг-i sakiju. qağalg-a-ban mandulağulqu

⁸⁶ Буяндэлгэр, Ж нар. (эмх.) *Dayičing gürün-ü dotoğadu yamun-u mongğol bičig-ün ger-ün dangsa*. Боть18, Kөkeqota: öbör mongğol-un yeke surğağuli-yin mongğol sudulul-un degedü surğağuli, 2005, 84-85 [0075-0076]. elhetaifin-idehijaqučianayasohohoihe. ilanbiyai ice-de suwyanmuturijuwan emu de sahalayan morin inenggi. huwangdi hese. tangu yabun-i sekiyen hiyoošun ci oyongu ebehe aqu. niyamal be weliyere. doro. haha.jui. sargan.jui emu adali unenggi ijishün erdemu omesi iletuleci. wesihun jergi bahabume fungnerengge giyan. weshun kemungge gunju si. mini sargan.jui. nesuken fujurangga banitai hesebuhe. gingun hūwalyasun-i doro be fongyaha. dorgi doron be ayifini urebufi maktacun deci gung hūwa de algingga. edu-de holboho manggi. erdemu jergiyen-i gurun boo de selgeyebuhe. jakan mini beyev elhe aqu de si gafi eršeme elhe be fonjime. jedere be tuwame hing seme gunin ba aqūmbuha: geren gunju-i dolo damu si uji. tudtu bime. se inu baha be dahame, qooli dorolon be jiramilaci iceme ofi. te cohome simbe wesihun gemungge gurun-i gunju fungnafi. aisin-i ce bithe buhe. ai. gehun genggiyen hesei bithe be wesimbume. hiyoošun ginggun-i unanggi gunin be temgetulehe. doshon derengge kesi be dabali isibume banjibure hūwašabure amba erdemu be badarambuha. kimuni ten-i ... urga be jiramilame ferguwecuke hūturi be ali. ginggule. engke amugululang-un döčin naimaduğar on sirağčın üker. qabur-un segül sar-a-yin sin-e-yin angq-a sar-a luu. arban nigen-e qar-a morin edür. quwangdi-yin jarlig. jağun yabudal-un nigen anu takimdaqu-ača erkin anu ugei. түрүл-i üiledküi yosun. köbegün ökin nigen adali bui. üneger ey-e-dü erdem masida iledte bolbasu. erkin jerge olğağul-un ergümjilekü anu jöb buyu. ülemji kemjijy-e-dü güngjü či minu ökin ür-e dölgen üjesküleng-dei. törölki jiyağasın anu. kičiyenggüi nayiramdağу bar yosun-i tegüskebei. dotogadu üliгер-i kedü-yin bolbasurağuluğad mağtağal anu ijağur-ača ordo qarsi-dur aldarsibai. efü-dür qolbağsan-u qoyin-a. erdem inu üneger olon ger-dür түgemel bolbai. tuğar minu biy-e amur ügei-dür. či irejü subilan. amugulang-i asğad. joqolaquiyi üjejü čing үnen sedkil-i бүридkebei: olan güngjü nar-un dotor-a gağča či erkin. teyimü böged. nasun basa yeke-yin tula. qauli yosun-i erkilbesü jokuqu-yin tula. edüge tuslan čimayi ülemji kemjijy-e-dü olon-u güngjü ergümjilejü. altan-i čwi bičig ögbe. ay-a. iletdegegegen jarlig bičig-i bağulgaju. takimdağу kičiyenggüi-dü үnen sedkil-i temdeglebei. čiqula nigurtai kesig-i ketürkei kürtegejü ayu түрүgүlküi күmүjigүlküi yeke erdem-i badarğulbai: mön kü tuyil-un yabudal-i erkilejü. ğayiqamsig-du buyan qutuğ-i küliyegtün kičiy-e:

buyan qutuḡ-i ülemḡi kičiyegteün. ergin bo...gtel-e arbijiqui-bar yabuḡu. ger-iyen nayiraldugulqu aldar-i egüride ülegegтүн: sayin keb-iyen buu aralḡigtun. qoyitu kesig-i mön kü amur bolḡ-a. kičiyegтүн: ⁸⁷

Үүнд эмэгтэй хүний гол баримтлах ёс суртахуун болох эр нөхөртөө үнэнч, цэвэр ариун явдлаар явах, ураг төрлийн хэлхээ, ялангуяа хадам эцэг эхээ өргөн асрах зэрэг гэрийн үйлийг чанад сахин биелүүлэх тухай Күнзийн сураалын үндсэн агуулга багтжээ. Үүнээс гадна Тэнгэрийн тэтгэсний 35-р он (1697)-д “*ulus-un efu lawangdorḡi-dur ibegeltei ulus-un güngjü-yi ergümjilekücölo-yi tngri-yin tedkügsen-iüḡücin tabuduḡar on ḡurban sara-yin arban qoyar-tu ayiladqaḡsan-dur jarliḡ nayiraltai čibsen kemeküüsüg keregletüḡei kemegsen-i tusiyan ḡarḡaḡad ḡurḡan-dur күргеjü irijügü*”⁸⁸, мөн түүнчлэн Хичээнгүй амирлангуй⁸⁹, Шулуун чин үнэмлэт⁹⁰ зэрэг тус тус цолууд өргөмжилж байсан байна. Ийнхүү цол өргөмжлөх нь монгол ноёдтой ураг холбосон Чингийн язгууртан эмэгтэйчүүдэд ч хамааралтай байжээ.

Мөн түүнчлэн тухайн үеийн эмэгтэйчүүдийг эрдэм номд шамдан суралцах талаар дэмжин, мэдлэг боловсролтой эмэгтэйчүүдэд тусгай цол олгодог байсны нэгэн жишээ бол Бадаргуулт төрийн 31-р он (1893)-д Халхын Жавзандамба хутагтын хатан Дондогдуламд, “*mongḡol ökin qubi jökiyal-un törölki mergen uqaḡatu bui böḡged ünenkü sanaḡ-a-bar nom ungsiqu-yin ucir-tur ... tegün-diir erdeni sečen kemegdekücöla šangnaju temdegtü bičig olḡaḡulḡu*”⁹¹ хэмээн Сэцэн эрдэнэ хэмээх цол өргөмжилжээ. Мөн түүнчлэн Богд хаант Монгол улсын 2-р онд Зоригт

⁸⁷ Буяндэлгэр, Ж нар. (эмх.) *Dayičing ḡürün-ü dotoḡadu yamun-u mongḡol bičig-iin ger-iin dangsa*. Боть18, Kökeqota: öbör mongḡol-un yeke surḡaḡuli-yin mongḡol sudulul-un dededü surḡaḡuli, 2005, 78-80 [0069-0080]. elhe taifin-i dehi nadaci aniya suwayan singgeri. forḡon biya ice-de sahaḡün hülmaḡün. juwan uyun-de fulaḡün meyihe inengi. quwangdi hese. joo dayan-de. dorolome bure be wesihuleme. da sargan jui de gingguleme seme tacibuhabi: ši ging de gigon hūwaliyasun be sayišame wang ni sargan jui be fujurangga seme maktahabi. dorgi dasan be urebuci ferguwecuke wesihun be isibure geyen: hošoi gungju si. mini sargan jui. mujilen. ginggün olhoba yabume. nesuken nemeyen. emḡei durben be gingguleme dahame. tacigeyan be gung ni dolo bisireci alhūdaha: hesei erdemu be jurcehaqu ofi. maktacun ele yigen-i buu de algika: abhai wisen wesihun de banjinjifi. amba boo de holboho. ioi deyen babehei hanci nayame ofi. wesihun ḡurun-de uhei ayisilamoi: sayin holbon acaha-be dajame. doroi etuku buci acambi. tuttu simbe te cohome uyen ginggün gungju funḡefi. ayisin-i ce bithe nememe kice: wesihun bime malahūsara be yabume. buu be huwaliyambure algin be ateheme titebu. sayin doron be ume halara. amaga wesihun be kemuni elhe obu. ginggule.

⁸⁸ УТА, М-10 Д№2 ХН№664-2.

⁸⁹ Оюунбилэг, З., Наранчимэг, Ж. *Гүнжийн сүм*, Улаанбаатар: Адмон, 2016, 36-37. 1723 онд Энх-Амгалан хааны зургадугаар охин, төрийн гэгийг Халхын Түшээт хан Чахундоржийн ач хүү, эфү Дондовдоржийн эхнэр болон ирэхэд түүнд Хичээнгүй Амирлангуй гүнж цол, Алтан навчит өргөмжлөл олгосон байдаг.

⁹⁰ <https://mn.wikipedia.org/wiki/> Сайн ноён аймгийн эфү Цэвээннэрин, Энх-Амгалангийн 45 дугаар он [1706] Шулуун чин үнэмлэт гүнжид холбож хошой эфү болгожээ. Найралт төвийн 10 дугаар онд улсын эфү болгожээ.

⁹¹ МУУТА, М-55 Д№1 ХН№321-1.

хан Содномжамцын хатан Пагмад “*nom-un dara*” хэмээх цол өргөмжлөх тухай, “*paḡma-dur nomungdar-a čola šangna, bas ġuyugsan yosuḡar bolḡaju tus tus ergümjilel šangnan baḡulḡaḡtun. olan-a ergügdegsen-ü qoyaduḡar on ebül-ün dumdada sarayin qorin doloḡan*”⁹² хэмээжүхүй. Ийнхүү зөв ёс суртахуун, ур ухаан, эрдэм мэдлэг бүхий монгол язгууртан эмэгтэйчүүдийг нийгэмд үлгэр дууриал болгох, нөгөө талаар тэднийг Чингийн төрд үнэнч, сүсэглэн дагуулах зорилго бүхий бодлого хэрэгжиж байжээ.

Рашпунцаг, Инжинаш зэрэг Чин улсын үеийн монгол зохиолч, сэтгэгч, түүхч нар ч Күнзийн сургаалийн нөлөөн дор зохиол бүтээлээ туурвиж байжээ.⁹³ Үүний нэг жишээ болвоос, Бат-Очир хэмээгчийн 1926 онд туурвисан “Мандах нарны туяа” хэмээх сургаал зохиолд, “эцэг эхийн ачийг хариулах талаар, Хөвүүн болсон хүн эцэг, эхийн ачийг түмэнд нэгэнтээ хариулсугай хэмээвээс дотроо бол сэтгэлээ гүйцэтгэн, гаднаа бол хүчээ дуусган чин үнэнхүүг зүрхнээс шамдаж, зүдгүүрийг хүлээж, ачлах гэжээхийг хичээвэл зохимуй”⁹⁴ хэмээгээд гэргий хүний сайн явдлын тухай “Аливаа мэргэн эм хэмээгч гэрийн сайжрал буюу ... Олонд сайхан ааль, эелдэг занг үзүүл. Хов үг танхилзуур инээдмийг тэвч. Хадам эцэг эхийг элбэрэн хүндэл. Уур хилэнг хүлцэж, айл аймагт сайхан зохиц. Садар эр, зусар эмийг бүү ойртуул. Нөхөр хэмээгч нэгэн насанд учирсан нь сайн хувь зохиол, хүндийн тулд найртайгаар хүндэл. Буруу явбал зүй зохисыг үзэж ятган хоригло”⁹⁵ зэргээр сургасан байдаг. Үүнээс харахад, Чин улсын үед Күнзийн сургаалын эш онол монгол нутагт дэлгэрч байжээ.

Үндэсний түүхийн төв архивын хөмрөгт Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын эхэн үед тэргүүн зэрэг ноёд язгууртнуудын хатдад олгож байсан ухуулах өргөмжлөлүүдэд зориулан зохиосон эхүүд хадгалагдаж байгаа билээ. Үүнд, Зостын чуулганы түшээ гүн Хайсангийн эхнэр Түмэнбаяр, Хөлөн буйр газрын туслан хэрэг шийтгэх сайд түшээ гүн Чэгжэний (сөгјен?) авааль гэргий Чойжил⁹⁶, дэд сайд бэйл Доржцэрэнгийн авааль хатан Ламжав⁹⁷, Цэцэн хан аймгийн мэргэн гүн Цэрэнвандуйбавуудоржийн төрсөн эх Ханджав⁹⁸, Зостын чуулганы чин

⁹² МУУТА, А-173 Д№1 ХН№87-8.

⁹³ Atwood, Christopher P. *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, Bloomington: Indiana University Press, 2004, 119.

⁹⁴ Бат-Очир, Ч. “Мандах нарны туяа” хэмээх сургаал, (эмх.) Шагдар. А., Осор, Б., Улаанбаатар: Монгол хэвлэл, 1992, 4.

⁹⁵ Бат-Очир, Ч. “Мандах нарны туяа” хэмээх сургаал, (эмх.) Шагдар. А., Осор, Б., Улаанбаатар: Монгол хэвлэл, 1992, 24.

⁹⁶ МУУТА, А-3 Д№1 ХН№49-217.

⁹⁷ МУУТА, М-36 Д№1, ХН№25-1.

⁹⁸ МУУТА, А-154 Д№1 ХН№8.

зүтгэлт улсад туслагч гүн Буянхишигийн авааль гэргий Алтанцэцэг⁹⁹, Гадаад яамны тэргүүн сайд, Түшээт хан аймгийн хан, сайныг удирдагч эрдэнэ дайчин засаг хошой чин ван Ханддоржийн авааль эхнэр хошой хатан Сэвжидмаа¹⁰⁰ мөн чин вангийн төрсөн эх хошой хатан Сосор¹⁰¹ нарт олгосон ухуулах өргөмжлөлүүд хадгалагдаж байна.

Чин ван Ханддоржийн авааль эхнэр хошой хатан Сэвжидмаа болон чин вангийн төрсөн эх хошой хатан Сосор нарт олгосон өргөмжлөлүүдийн талаарх судалгааны бүтээлдээ Э.Жигмэддорж, Богд хаант Монгол улсын үед “төрд үнэн сэтгэлээр зүтгэсэн ноёд түшмэдэд хааны зарлигаар цол хэргэм шагнах, тэдний эх, хатан нарт өргөмжлөлийн бичиг олгох тогтсон дэг жаягтай” байсан бөгөөд “Навчит өргөмжлөл” “Шар торгон жуух өргөмжлөл”, “Ухуулах өргөмжлөл” гэх мэт төрөл зүйлтэй байсан талаар өгүүлэхийн сацуу, тэдгээр нь “хувь хүний намтарт холбогдох чухал сурвалж болохын зэрэгцээ тухайн үеийн Монголын улс төрийн бодлого, үйл ажиллагааг судлахад зохих ач холбогдолтой” талаар өгүүлсэн.¹⁰² Мөн тэрээр “Богд хаанаас чин ван Ханддорж болон Өвөр Монголын ноёд, тэдний хатан нарт өргөмжлөл олгосон нь тэдний хичээл зүтгэлийг үнэлэхийн хамт Монголын тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд чиглэсэн алхам байсан” тухай дүгнэжээ.¹⁰³

Тэдгээр зохиосон эхүүдэд мөн л эр нөхөртөө үнэнч, цэвэр ариун явдлаар амьдрах, ураг төрлийн хэлхээ холбоог үргэлжид дээдлэн явах, энэхүү ариун журмыг сахиж чадсан тул олгож байгаа тухай дурдахын зэрэгцээ хойшид ч эелдэг зөөлөн сэтгэлээр бүгдийг энэрэн халамжилж, омог бардам зан үл гаргах талаар сургасан байдаг. Чин ван Ханддоржийн хатан Сэвжидмаад олгосон өргөмжлөлийн зохиосон эхийг бүрэн эхээр нь дор сийрүүлэв.

jokiyaḡsan eke

dotoḡadu kereg-i бүгүде jakirun sidkeḡci yamun-u biḡig

tamaḡ-a daruḡsan ergүmјilel biḡig olḡoju qadḡalaḡuluḡsan-u uḡir, edүge olan-a ergүgdeḡsen-ү dörbedүger on arban qoyar sar-a-yin sin-e-yin ...dur

degedү jarliḡ baḡulḡaḡsan anu,

⁹⁹ МУУТА, А-173 Д№1 ХН№126-9.

¹⁰⁰ МУУТА, А-173 Д№1 ХН№126-11.

¹⁰¹ МУУТА, А-173 Д№1 ХН№126-12.

¹⁰² Жигмэддорж, Э. “Богд хаанаас Чин Ван Ханддоржийн эх Сосор, хатан Сэвжидмаа нарт олгосон өргөмжлөлийн тухайд,” *Эрдэнэ дайчин хошой чин ван М.Ханддорж (Эрдэм шинжилгээний бага хурлын материал)*. Улаанбаатар, 2010, 98-108.

¹⁰³ Жигмэддорж, Э. “Богд хаанаас Чин Ван Ханддоржийн эх Сосор, хатан Сэвжидмаа нарт олгосон өргөмжлөлийн тухайд,” *Эрдэнэ дайчин хошой чин ван М.Ханддорж (Эрдэм шинжилгээний бага хурлын материал)*. Улаанбаатар, 2010, 407.

šasin törö-yin qooslan bariğči naran gereltü tumen nasutu boğda ejen qağan-u jarlig, gadağadu-yin yamun-u terigün sayid, tüsiyetü qan ayimağ-un qan-u jerge, sayin-i udariduyçi erdeni dayičin jasay qoşoi čin wang qangdadorji-yin abali qoşoi qatun sebjidm-a bolbasu angq-a qadamlaysan-ača inağsi ger-ün yosu-yi bolgomjilan, čeber içimtegei-ber kelkiy-e jirum-i sakiju yabuğsan-u tulada, čimadur ergümjilel olğagulbai. čiber kisig-i süsülen bolgomjilan yabuğtun, buu omorqağ bardamlaju, jirum kelkiy-e-yi ütegerküi-dur kürügültugei kemegsen-i kičiyenggüyilen dağaju, man-u dotoğadu yamun-ača tamay-a daruğsan bičig ergümjilel sidken gargaaju, sayid qan-u jerge sayin-i udariduyçi erdeni dayičin jasay qoşoi čin wang qangdadorji-yin abali qoşoi qatun sebjidm-a-dur qadğalağulbai. olan-a ergügdegsen-u dörbedüger on arban qoyar sara-yin sin-e-yin¹⁰⁴

хэмээжээ. Ийнхүү эмэгтэй хүний гол үүрэг болох эр нөхрөө халамжлах, үр хүүхдээ өсгөх, ураг төрлийн хэлхээ холбоог чандлан сахих, цэвэр ариун явдлыг чандлан сахих тухай зөв ёс зүйг уриалан дуудсан агуулгатай байна.

Мөн тухайн үед өргөмжлөл олгох тусгай дэг жаяг, ёс журмын дагуу явагдах талаар Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улсын 2-р онд зохиогдсон “jarlig-iyar toğtoğağsan monggol ulus-un qauli jüil-ün bičig”-ийн 31-р бүлэгт,

nigen jüil, qan, wang, beyile, beyise-yin qatun güng-un gergei-dür uqağulqu ergümjilel olğagul, čöm sir-a čağasun-dur bičigtün. öber öber-ün qariyatu gajar-ača ergümjilel-i küliyekü qatun gergei-yin ner-e obuğ nasu qadamlaju qolbağsan jil angq-a abuğsan darağ-a abuğsan jerge-yi todorqayilan gargaaju dotoğadu yamundur medegülür-e ir-e. dotoğadu yamun-ača uqağulqu ergümjilel-ün eke jokiyан ayiladqaju jarlig-iyar toğtoğağsan-u qoyin-a kičiyneggüilen bičijü erdeni tamağ-a daruju olğagul. jasağ tayiji-ača dorogsi түsimel-ün gergei jiči üy-e jalgamjilaqu kergem jerge busu bolbasu ergümjilel olğagulqui-yi keregseküügei bolğagtun¹⁰⁵

хэмээн заасан байдаг.

Дүгнэлт

Монгол эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийг илэрхийлэх мөн эрхэм дээд ёс суртахууныг магтан сайшааж, нийгэмд үлгэр жишээ болгох зорилго бүхий язгууртан эмэгтэйчүүд, хатдад цол, өргөмжлөл олгох уламжлал нь монголчуудын төрт ёсны салшгүй нэг хэсэг байжээ. Юань улсын үед хөгжлийн шинэ шатанд гарсан бөгөөд монгол хатад, “төр улсын сан хөмрөгийг арвилан хэмнэх, хааны ордон дахь дүрэм журам, дэг ёсыг тогтоох, ахуй соёлын шинэ хэв маягийг дэлгэрүүлж, өөрийн биеэр...

¹⁰⁴ МУУТА, А-173 Д№1 ХН№126-11.

¹⁰⁵ МУУТА, А-235 Д№1 ХН№33.

үлгэр дуурайлал үзүүлэн”¹⁰⁶ нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадсаны төлөө төрийн их хүндэтгэл хүлээж, цол нэр хүртэж олонд хүндлэгдэж байжээ.

Ноёд язгууртнуудад байгуулсан гавьяа зүтгэлийг нь үнэлэн “хүнд”, “зузаан” хишиг хүртээх, цол хэргэм шангах нь хатад эмэгтэйчүүдийг ч тойрсонгүй. Улмаар Чин улсын үед монгол язгууртнуудад цол хэргэм өргөмжлөх үйл явц нь тусгай дэг жаяг, шалгуурын дагуу хуулийн дагуу хэрэгжих болж эрхзүйн шинэ орчин бүрэлдэн тогтсон ажээ. Үүний нэг жишээ бол тухайн эхнэрийн цол хэргэм нь нөхрийн хэргэм зэргээс шалтгаалан, *ċin wang*-ийн эхнэрт *qosoi qatun*, *jüin wang*-ийн эхнэрт *törö-yin qatun*, *beyile*-ийн эхнэрт *törö-yin beyile-yin qatun*, *beyise*-ийн эхнэрт *qosigun-u beyise-yin qatun*, *güing*-ийн эхнэр *noyaaqan* хэмээх цол олгох хуультай болжээ.

Монгол язгууртнуудад цол хэргэм өргөмжилсөн, угсаа залгамжилсныг батлах тусгай баримт буюу өргөмжлөл олгох ба үүнд Чингийн төрд, “*güing bayigulju jidkügsen anu. yekede sayisiyaltai-yin tulada*” уг цол хэргэм буюу “*qayiqamsigtu kesig-i*” буулган тархааж буй тул хойшид мөн зүтгэх тухай өгүүлсэн байдаг. Харин язгууртан эмэгтэйчүүдэд цол хэргэм олгох нь тэднийг эр нөхөртөө үнэнч сэтгэлээр туслах хэлхээ журмыг чандлан сахисанаар эр нөхөр нь Чингийн төрд гавьяа байгуулсан тул олгож буй талаар ухуулан тайлбарласан байдаг ба энэ нь тухайн үеийн нийгмийн ёс суртахууны асуудалтай холбогдоно.

Монголчууд харийн эрхшээлд орсон хоёр зуугаруй жилийн хугацаанд улстөр, эдийн засаг, хууль эрхүйн хувьд аажмаар Манжийн нөлөөнд орж¹⁰⁷, нийгмийн ёс суртахуун ч үүнээс гадна хоцорсонгүй. Дээрх өргөмжлөлүүдийн эх бичвэрүүдэд эмэгтэйчүүдийг нийгмийн тодорхой ангилалд хамруулж, түүндээ тохирсон ёс зүйг дагах, ялангуяа язгууртан эмэгтэйчүүд ёс журмыг илүү өндөр түвшинд сахих ёстой талаар сургасан Күнзийн сургаалын үндсэн санаа гүн гүнзгий агуулагдаж байсан нь илэрхий. Жишээ нь, 1636 онд Хорчины Бумбатай хатанд олгосон өргөмжилөлд, “Ёс суртахууны гурван харилцаа” (эзэн-харьяат, эцэг-хүү болон эхнэр-нөхөр) болон “Эрхэмлэх таван чанар” (хүнлэг чанар, үнэнч шударга, эрдэм мэдлэг, итгэл хүлээх, эе зохис)-ын тухай сураалын тухай өгүүлсэн байна.¹⁰⁸ Энэ нь монголчууд харийн эрхшээлээс гарч өөрийн тусгаар улсаа байгуулсан эхэн үед ч мөн нөлөөлсөн хэвээр байжээ.

¹⁰⁶ Идэр, О., Тайвансүрэн, С. *Монголын Их Хатад*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2019, 95-98.

¹⁰⁷ “Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*,” 2004:334 мөн “Heuschert, *Legal pluralism in the Qing Empire: Manchu legislation for the Mongols*,” *The International History Review*, Vol.20, No 20 (1998), pp. 323.

¹⁰⁸ Wang, Peihuan., “Hong Taiji’s Patent to His zhuangfei Concubine Bumbutai”, *Beitrage zur Geschichte, Sprache und Kultur der Manchuren und Sibe*, Martin Gimm, Giovanni Stary, Michael Weiers (Hrsg). Wiesbaden: Harrassowitz, (Aetas Manjurica 6), 1998, 145-155.

Abstract

Granting honorific titles and ranks to preexisting local rulers was not invented by the Qing court; it had a long tradition in the history of all Chinese dynasties. The Qing rulers used it to maintain its influence over its subject peoples by retaining the existent power structure and familiar administration. Moreover, granting honorific titles to women of noble origin aimed to praise and propagate the preferred qualities of moral and ethical conduct by perpetuating and promoting the wise mothers and virtuous wives ideal. While examining honorific titles and ranks bestowed on Mongol women of noble origin, this paper investigates how the dynamics of Manchu-Mongol relations influenced administrative practices in Mongolia during this period through analyses of archival documents in Mongolian National Archives from the Qing period. Particularly, this work considers the *ergümjilel*, an official document bestowed by the Qing emperor along with the noble ranks granted to Mongolian noblewomen, its social importance, how it promoted certain ethical behaviors deemed proper in women, how it was perceived by the Mongols, and a description of the procedure of requesting and bestowing this official honorific title.

Ном зүй

1. Atwood, C. *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*, Bloomington: Indiana University Press, 2004.
2. Atwood, C. "Worshiping Grace": The Language of Loyalty in Qing Mongolia," *Late Imperial China* vol. 21, no. 2, 2000.
3. Бат-Очир, Ч. "Мандах нарны туяа" хэмээх сургаал, (эмх.) Шагдар. А., Осор. Б., Улаанбаатар: Монгол хэвлэл, 1992.
4. Birge, B. *Women, Property, and Confucian Reaction in Sung and Yüan China (960-1368)*, Cambridge: Cambridge University Press, 2002.
5. *Dayicing gürün-ü dotogadu yamun-u monggol bičig-ün ger-ün dangsa*, (эмх.) Буяндэлгэр, Ж., Оюунбилэг, Б., Эү Юван Пэнг. Боть18, kökeqota: öbör monggol-un yeke surgaguli-yin monggol sudulul-un degedü surgaguli, 2005.
6. Elliot, M. "Manchu Widows and Ethnicity in Qing China," *Comparative Studies in Society and History* 41, no. 1, 1999, 33-71.
7. Elverskog, J. *Our Great Qing the Mongols, Buddhism and the State in Late Imperial China*, Univ. of Hawai'i Press, 2008.
8. Framke, W. "Patents for Hereditary Ranks and Honorary Titles during the Ch'ing Dynasty", *Monumenta Serica*, vol. VII, fasc. 1/2, 38-67, 1942.
9. Гэрэлбадрах, Ж. "Дөчин , Дөрвөн хоёрын" Монгол улсын язгууртны цол зэрэг, Улаанбаатар: Бемби сан, 2010.

10. *Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илгэл шастир*, (эмх.) Цэрэндорж, Ц., Эрдэнэболд, Л., Баржав, Д., Ганбат, Н. Улаанбаатар, 2007.
11. Heuschert, D. "Legal Pluralism in the Qing Empire: Manchu Legislation for the Mongols", *The International History Review*. Vol. 20. No. 2. 1998. pp. 310-324.
12. Жигмэддорж, Э. "Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй нэгэн өргөмжлөлийн тухай", *Quaeriones Mongolorum Disputatae*. vol.5. Токуо, 8-28, 2009.
13. Жигмэддорж, Э. "Богд хаанаас Чин Ван Ханддоржийн эх Сосор, хатан Сэвжидмаа нарт олгосон өргөмжлөлийн тухайд", *Эрдэнэ Дайчин Чин Ван Ханддорж*, Улаанбаатар, 98-109, 2009.
14. Jigmeddorj, E. "The Certificate on the titles Inheritance written in Manchu and Mongolian text given to Dürbed Dalai khan by Qing dynasty", *Oyirad Studies*. vol.3. Budapest, 9-27, 2017.
15. Зэнз. *Их суртахуй*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ, Улаанбаатар: Адмон, 2013.
16. Зы Си. *Хэв дундын ёсон*, хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ, Улаанбаатар: Адмон, 2013.
17. Идэр, О., Тайвансүрэн, С. *Монголын Их Хатад*, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2019.
18. Кунз, *Шүүмжлэлт өгүүлэл*, Хятад хэлнээс орч. М. Чимэдцэеэ Улаанбаатар: Адмон, 2013.
19. Lessing, F. *Mongolian-English Dictionary*, Bloomington: The Mongolia Society, Inc, 1995в
20. Лувсанбалдан, Х. *Ачлалт номын тухай*, Улаанбаатар: ШУДБХ Эрдэм Шинжилгээний Хэвлэлийн газар, 1961.
21. Mann, S. "Widows in the Kinship, Class, and Community Structures of Qing Dynasty China," *The Journal of Asian Studies*, Vol.46, No.1, 1987, 37-56.
22. Mann, S., Yu-Yin, Ch. *Under Confucian Eyes*, University of California Press: Berkley, 2001.
23. *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл /1206-1910/*. Боть. (эмх.) Чимид, Б., Баярсайхан, Б. Улаанбаатар, 2010.
24. Norman, J. *Comprehensive Manchu-English Dictionary*, Cambridge: Harvard University Asia Center Press, 2013.
25. Оюунбилэг, З., Наранчимэг, Ж. *Гүнжийн сүм*, Улаанбаатар: Адмон, 2016.
26. Pang, T.A. "A Manchu-Mongolian Diploma Given to the Wife of Mongolian Nobleman", *Written Monuments of the Orient*. Russian Academy of Sciences. Institute of Oriental Manuscripts, 78-86, 2015.
27. Pang, T.A. "The Imperial Patent of the Kangxi Period in the Collection of the Institute of Oriental Manuscripts, Russian Academy of Sciences", *International Conference. China and Central Asia from the Pre-Mongol to the Post-Mongol periods: History and Culture*. Conference Proceedings, 64-66, Sep.23-24, 2017.

28. Rosenlee, L. *Confucianism and Women*, State University of New York Press: Albany, 2006.
29. *Saghang Sečen's Erdene-yin Tobči*, (эмх.) Gō, M. I.de Rachewiltz. Kruger, J. and Ulaan, B. Australia: Australian National University Press, 1990.
30. Урангуа, Ж. *Хэргэм, зэрэг, цол өргөмжлөхүй*, Улаанбаатар: Наранбулаг Принтинг, 2000.
31. Цэвэл, Я. *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1966.
32. Veit, Veronica. "A Set of 17th to 19th Century Manchu-Mongolian Patents", *Tumen jalafunjecenakū*. Manchu Studies in Honour of Giovanni Stary. (эмх.) A. Pozzi and J.A. Janhunen and M. Weiers. Wiesbaden: Harrasowitz, 245-253 (*TungusoSibirica* 20), 2006.
33. Wang, Peihuan. "Hong Taiji's Patent to His zhuangfei Concubine Bumbutai", *BeitragezurGeschichte, Sprache und Kultur der Manchuren und Sibe*. Martin Gimm, Giovanni Stary, Michael Weiers (Hrsg). Wiesbaden: Harrasowitz, 145-155 (*AetasManjurica* 6), 1998.